


ИНЕГ-ЫН ДОТООД АУДИТЫН 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2013.12.16

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тасаг нь Зам, тээврийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 68 дугаар тушаалаар батлагдсан ИНЕГ-ын зохион байгуулалтаар бүтцээр ИНЕГ-ын даргын шууд удирдлага дор тасгийн дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн 1, аудитор 3 нийт 5 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.



1. Дотоод аудитын чиглэлээр:

“Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан, ИНЕГ-ын даргын 6 дугаар сарын 24-ний өдрийн А/326 дугаар тушаалаар батлууллаа. Мөн дотоод аудитын ажлын тайлан, аудитаар илэрсэн асуудлын бүртгэл, илэрсэн асуудлын жагсаалт, төлбөр зөрчлийн акт, сануулах хуудас зэрэг маягтуудыг батлуулан, үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

2013 онд хийгдсэн төлөвлөгөөт аудит:

Дотоод аудитын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод аудит хийх хуваарийг ИНЕГ-ын даргаар батлуулан, батлагдсан хуваарийн дагуу ИНЕГ-ын дотоод зохион байгуулалтын 2 нэгж, 8 алба, харьяа байгууллагад дотоод аудит хийлээ. ИНЕГ-ын Санхүү, эдийн засгийн газрын өнгөрсөн 2 жилийн үйл ажиллагаанд аудит хийж байгаа учраас хүний нөөц, цаг хугацааны байдлаас хамааран орон нутгийн нисэх буудлуудад хийх дотоод аудит ажлыг гүйцэтгэсэнгүй.

№	Шалгалтад хамрагдсан байгууллага	Хугацаа
1.	Агаарын навигацийн үйлчилгээний газар /Агаарын хөдөлгөөний үйлчилгээний алба, Техник хангалт, үйлчилгээний алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Шалгалтын нислэгийн зураглалын алба/	2012.12.24 -2013.02.18
2.	Газрын үйлчилгээний алба	2013.03.01-2013.04.12
3.	“Чингис хаан” олон улсын буудал	2013.04.25-2013.07.25
4.	Буянт-Ухаа ресторан	2013.05.10-2013.06.10
5.	Сэргээн засал сувиллын цогцолбор	2013.04.25-2013.05.22
6.	Санхүү, эдийн засгийн газар /Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, захиалагчийн алба/	2013.09.09-2013.12.30

Төлөвлөгөөт бус аудит:

№	Шалгалтад хамрагдсан үйл ажиллагаа	Хугацаа
1.	Тус газрын зардлаар оюутан сургахаар SABO институт, “Замдаан” сэтгүүлтэй байгуулсан гэрээ	2013.05.27 -2013.06.05
2.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж явуулсан хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлын явц /2011-2012 он/	2012.12.13-2013.03.28
3.	Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын санхүүгийн баримт	2013.05.23-2013.05.27
4.	Сэргээн засал, сувиллын цогцолборын касс	2013.10.04
5.	Завхан, Говь-Алтай аймаг дахь нисэх буудлын хатуу хучилттай зурвас, үерийн далангийн барилгын ажлын явц	2013.12.16-2013.12.30
6.	ИНЕГ-ын харилцах данс болон кассан дахь бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээнд хэсэгчилсэн хяналт шалгалт	2013.12.01-2013.02.15

2013 онд илрүүлсэн зөрчил, дутагдал түүний барагдуулалтын байдал

2013 онд нийт 52 зөвлөмжийг харьяа нэгж хэсгүүдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Нийт 52 зөвлөмжөөс хэрэгжсэн 38, хэрэгжилтийн шатандаа байгаа 14 байна.

№	Байгууллагын нэр	Зөвлөмж	Хэрэгжилт	Хэрэгжилтийн шатандаа байгаа
1	Агаарын навигацийн үйлчилгээний газар /Агаарын хөдөлгөөний үйлчилгээний алба, Техник хангалт, үйлчилгээний алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Шалгалтын нислэгийн зураглалын алба/	5	5	
2	Газрын үйлчилгээний алба	5	2	3
3	“Чингис хаан” олон улсын буудал	26	25	1

4	Хөвсгөл аймаг дахь нисэх буудал	2	2	
5	Хөрөнгө оруулалт, захиалагчийн алба	-		
6	Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	-		
7	Буянт-Ухаа ресторан	-		
8	Сэргээн засал, сувилалын цогболбор	14	4	10
Нийт		52	38	14

Гарч буй зөрчил дутагдлыг ангилбал:

№	Зөрчлийн утга	Эзлэх хувь
1	Буруу олгогдсон цалин	0.71 %
2	Буруу олгогдсон үр дүн, удаан жилийн нэмэгдэл	0.27 %
3	Буруу олгогдсон тэтгэмж	0.02 %
4	Суутгаж аваагүй эмнэлэгийн үзлэгийн төлбөр	0.08 %
5	Батлагдсан нормгүй олгосон сүүний үнэ	0.01 %
6	Суутгаагүй ХХОАТ	0.06 %
7	Буруу суутгасан ХХОАТ	0.06 %
8	Дутсан бараа материал	0.10 %
9	Анхан шатны баримтгүй олгосон бэлэн мөнгө	0.08 %
10	Дутуу хийгдсэн ажлын хөлс	3.28 %
11	Гүйцэтгээгүй ажлын хөлс	7.58 %
12	Зарцуулаагүй материалын үнэ	0.03 %
13	Чанаргүй бараа материал авсан	0.95 %
14	Алданги	2.34 %
15	Хууль зөрчиж байгуулсан гэрээ	84.44 %
	Дүн	100%

Цаашид дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Дотоод аудитын дүрмийг боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах; *(Дотоод аудитын дүрэм нь дотоод аудитын нэгжийн зориулалт эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхойлсон албан ёсны баримт бичиг мөн. Дотоод аудитын дүрэм нь байгуулага дахь дотоод аудитын байр суурь, түүний дотор аудитын гүйцэтгэх удирдлага чиг үүргийнхээ талаар зөвлөлд тайлагнах харилцааг тогтоож, ажил гүйцэтгэхтэй холбоотой баримт бүртгэл, боловсон хүчин, биет хөрөнгөтэй харьцах эрх олгосон, дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхойлдог.)*
- Байгууллагын санхүүгийн, үйл ажиллагааны, стратегийн, нийцлийн эрсдлүүдийг тодорхойлж, дотоод аудитын 3 жилийн стратеги, төлөвлөгөөг боловсруулан, эрсдэлтэй үйл ажиллагаанд аудит хийх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ